



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/145

Номгон

Иргэн Б.Сундуйсүрэнд газар
өмчлөх эрхийг шилжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар өмчлөх эрх шилжүүлэх гэрээний дагуу гэр бүлийн гишүүд болох иргэн Д.Алтанцогоос өмчлөх эрхийг үнэ төлбөргүйгээр иргэн Б.Сундуйсүрэнд шилжүүлсүгэй.

2.Өмчлөх эрхээ шилжүүлж буй болон шилжүүлэн авч буй иргэний үндсэн мэдээллийг хавсралтаар баталсугай.

3.Газар өмчлөх эрхээ шилжүүлсэн болон шилжүүлэн авч байгаа иргэнд хууль тогтоомжид заасны дагуу газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлэх асуудлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Баянхонгор сумын Засаг дарга (М.Насанбат), Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал), өмчлөлийн газрыг зориулалтын дагуу зүй зохистой ашиглахыг газар өмчлөгч Б.Сундуйсүрэн нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Энхбаяр), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл) нарт тус тус даалгасугай.

5.Энэ захирамж гарсантай холбогдуулан шилжүүлж байгаа иргэний 2009 оны 349 дүгээр захирамжийн 135 дахь хэсгийн иргэнтэй холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

626010385

D:\2026\1.Zakhiramj\Zahiramj 01.docx

Аймгийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 10 -ны
 өдрийн А/145 дугаар захирамжийн хавсралт



ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХ ГЭР БҮЛИЙН АЛЬ НЭГ ГИШҮҮНД ҮНЭ

Д/Д	Овог	Нэр	Ам бүл	Хаяг	Газрын хэмжээ /м2/	Гэр бүлийн хамтын хэрэгцээнд өмчилж			Өмчлөх эрх шилжүүлэг- чийн эцэг эхийн нэр	Өмчлөгч эрх шилжүүлэг- чийн нэр	Өмчлөх эрх шилжүүлэн авагч			Гэрчилгээний дугаар
						Огноо	Дугаар	Хавсралтад орсон дугаар			Овог	Нэр	Регистрийн дугаар	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
1	Дүгэрсүрэн	Алтанцог	2	5--3--3	407.4	2009.09.10	349	135	Дүгэрсүрэн	Алтанцог	Бор	Сундуйсүрэн	ВЮ98111319	Г-0320003007

-----оОо-----

